



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 443

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн нийт 42,111,100.00 (дөчин хоёр сая нэг зуун арван нэгэн мянга нэг зуун) төгрөгийн балансын үнэ, 25,117,135.34 (хорин таван сая нэг зуун арван долоон мянга нэг зуун гучин таван төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн
443 дугаар тогтоолын хавсралт

"ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Видео ханын дэлгэц 49 инч	8/14/2017	ш	4	5,869,700.00	23,478,800.00	14,185,108.43	9,293,691.57
2	Ханын дэлгэцийн удирдлагын процессор /wall controller Dexon DXN- 4204U4, 4 Screen, 4x Universal Input/	8/17/2017	ш	1	15,202,200.00	15,202,200.00	9,184,662.50	6,017,537.50
3	Видео ханын дэлгэцийн суурь	8/17/2017	ш	1	830,200.00	830,200.00	501,579.07	328,620.93
4	Телевизор Samsung UE55M5500AUXCELED 55 инч	2/5/2018	ш	1	2,599,900.00	2,599,900.00	1,245,785.34	1,354,114.66
Нийт дүн						42,111,100.00	25,117,135.34	16,993,964.66
						(дөчин хоёр сая нэг зуун арван нэгэн мянга нэг зуун)	(хорин таван сая нэг зуун арван долоон мянга нэг зуун гучин таван төгрөг гучин дөрвөн мөнгө)	(арван зургаан сая есөн зуун ерөн гурван мянга есөн зуун жаран дөрвөн төгрөг жаран зургаан мөнгө)